



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 107

Улаанбаатар хот

“ТДМ” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн
хугацааг сунгах тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 405 дугаар тогтоолоор батлагдсан Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журмын 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “ТДМ” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2015 оны 8 дугаар сарын 05-ний өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд холбогдох тэмдэглэгээг 2016 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор хийлгэхийг “ТДМ” ХЗХ /Д.Ганболд/-нд үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, холбогдох өөрчлөлтийг Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Ю.Нэргүй/-т, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧИ,
ДЭД ДАРГА



Э.БАТБОЛД